

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А-94
дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

(2018-2025)

Энэхүү бодлогын баримт бичгийг Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк, Япон улсын Ядуурлыг бууруулах сангийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Салбар, орон нутгийн жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” техник туслалцааны төслийн Жендэрийн зөвлөх багийн дэмжлэгээр боловсруулав.

Нэр томьёоны товч тайлбар

- 1. Ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр:** Эмэгтэй, эрэгтэй ажиллагсдын гэр бүлийн үүрэг хариуцлагыг анхаарч тооцоогүй бодлого төлөвлөлт нь эмэгтэйчүүдийг ажлын байрандаа ахиж дэвшихэд садаа болж, цалин хөлс багатай, баталгаагүй ажил руу түлхдэг ба харин эрэгтэйчүүдийг гэр бүлийнхээ амьдралд оролцох боломж, чадварыг нь хязгаарлан эрүүл мэндийн эрсдлийг нь ихэсгэдэг. Тиймээс хөдөлмөр эрхлэлт болон гэр бүлийн үүрэг хариуцлагыг зохистойгоор хослуулж ажил-ар гэрийн тэнцвэрийг хангах нь жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцын нэгэн хэсэг болж байна.
- 2. Жендэрийн дүн шинжилгээ:** Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм. Үүнд зөвхөн хүйсээр ангилсан мэдээлэл бус, бодлогын дүн шинжилгээ, чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигладаг.
- 3. Жендэрийн мэдрэмж:** Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадварыг тодорхойлсон ойлголт.
- 4. Жендэрийн статистик:** Хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулах, нэгтгэх, шинжлэх, бодлого төлөвлөлтөд ашиглах замаар жендэрийн тулгамдсан асуудлыг илүү тодорхой ойлгох, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тооцох арга хэрэгсэл.
- 5. Жендэрийн тэгш байдал:** Эмэгтэй, эрэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж, хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдсан байдал.
- 6. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх (Gender mainstreaming):** Аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, түүний дотор хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт эмэгтэй, эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршлагыг эн тэнцүү үнэлж, анхаарах үйл явц, стратеги.
- 7. Жендэрийн хэвшмэл ойлголт:** Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн шинж төрх, байр суурь, гүйцэтгэх үүргийн талаарх хувь хүмүүсийн ялгаатай байдал, цаг хугацааны явц дахь өөрчлөлтийг үл тооцсон хялбаршуулсан ойлголт төсөөлөл, явцуу итгэл үнэмшил, хүлээлт. Хэвшмэл ойлголт нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг бодлого төлөвлөлтөд анхаарч тусгахад садаа болж, шударга бус хандах, аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг.
- 8. Жендэрийн хяналтын хуудас:** Төрийн үйлчилгээ, төслийн үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангасан байдлыг бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээний бүх шатанд үнэлэх зорилгоор тусгайлан боловсруулсан асуултууд буюу үзүүлэлтүүдийн жагсаалт бүхий хяналтын арга хэрэгсэл.
- 9. Жендэрийн шалгуур үзүүлэлт:** Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тоон болон чанарын үзүүлэлтүүд. Жендэрийн шалгуур үзүүлэлтүүд нь үйл ажиллагааны үр дүнд хувь хүмүүст, айл өрхөд ямар ахиц дэвшил гарч байгааг харахад тусална.
- 10. Хүйсээр ангилсан мэдээлэл:** Хүнтэй холбоотой аливаа статистик мэдээллийг хүйсээр, мөн нас, албан тушаалын зэрэглэл зэрэг холбогдох бусад үзүүлэлтээр ангилан цуглуулж, тайлагнах нь жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх эн тэргүүний алхам юм. Мөн салбар, байгууллагын үйл ажиллагаанд бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн оролцооны дүр зургийг гаргахад хүйсээр ангилсан мэдээлэл тусална.

Өмнөх үг

Жендэрийн тэгш байдал нь хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх боломжийг эмэгтэй, эрэгтэй хүмүүст, нийгмийн бүлгүүдэд тэгш бүрдүүлэх тухай ойлголт бөгөөд өнөөдөр Тогтвортой хөгжлийн зорилго 2030-ийн “хөгжлийн явцад хэнийг ч үл орхигдуулах” зарчмыг хэрэгжүүлэх арга зам болж байна. Төрийн үйлчилгээ, доноруудын дэмжлэг тусламжийг аль болох хүртээмжтэй, үр өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэхийн тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн харилцан адилгүй үүргээс үүдэлтэй ялгаатай хэрэгцээг анхаарч тооцох, тэдэнд тулгарч буй саад бэрхшээлийг судлан шинжилж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тэдгээрийн хэрэгжилт болон хяналт үнэлгээнд ашиглахад жендэрийн онол, арга зүй өнөөдөр тусалж байна.

Бүх насны эмэгтэй, эрэгтэй ажиллагсдыг аливаа ялгаварлан гадуурхал, шударга бус хандлагаас сэргийлсэн ажлын орчин нөхцлийг бүрдүүлэх, ялгаатай хэрэгцээг анхаарч ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах нь байгууллагын хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувь хүний, гэр бүлийн хөгжлийг дэмжих арга зам юм. Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт нь ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, бүх түвшинд түншлэл, хамтын ажиллагааг сайжруулахад нөлөөлдөг.

Монгол Улс нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 оноос баталж, хэрэгжүүлэх тогтолцоог үндэсний болон аймаг, дүүргийн түвшинд бүрдүүлэн ажиллуулснаар бүс нутагтаа үлгэр жишээ, сайн туршлага болж байна. Монгол Улс дахь жендэрийн нөхцөл байдалд үндэслэн боловсруулж, 2002-2016 онуудад хэрэгжүүлсэн Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр болон 2017-2021 онд хэрэгжиж буй шинэ хөтөлбөрт эмэгтэй, эрэгтэй хүмүүст тулгамдаж буй асуудал, тэдний ялгаатай хэрэгцээг эн тэнцүү хэмжээнд анхаарч шийдвэрлэх хандлагыг баримталж байна. Гэвч жендэрийн тэгш байдлыг хүйсийн харьцаа төдийгөөр, эсвэл эмэгтэйчүүдийн асуудал мэтээр төсөөлөх байдал оршсоор, жендэрийн онол, арга зүйг бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд ашиглах ур чадвар дутмаг хэвээр байна.

Монгол Улсын ажиллах хүчний талаас илүү хувийг хамарч буй хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар нь жендэрийн талаар баримтлах бодлогыг үйл ажиллагааныхаа онцлогт нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн нь салбарын байгууллагуудын хүний нөөцийн хөгжилд төдийгүй өргөн уудам нутагт ажиллаж амьдарч буй эмэгтэй, эрэгтэй нийт хүмүүст үр өгөөжтэй билээ. Энэхүү жендэрийн бодлого нь мөн малчид, газар тариаланчид, хөнгөн ба хүнсний үйлдвэрт ажиллагсдад тулгамдаж буй асуудлыг шийдэхэд салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг идэвхижүүлэх, олон улсын түвшинд хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг болно хэмээн найдаж байна.

Жендэрийн зөвлөх баг

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын жендэрийн нэгдсэн бодлого нь (цаашид “Салбарын жендэрийн бодлого” гэнэ) тус салбарын бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналт үнэлгээг, мөн хүний нөөцийн болон түншлэл хамтын ажиллагааны хөгжлийг жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйгээр дэмжих үйл ажиллагааны хүрээг тодорхойлсон дунд хугацааны бодлогын баримт бичиг юм. Энэхүү салбарын жендэрийн бодлого нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021) болон Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (2014-2025), Төрөөс малчдын талаар баримтлах бодлого (2009-2020), Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого (2015-2030) болон салбарын бусад бодлого төлөвлөлт, үйл ажиллагаатай уялдан хэрэгжинэ.

Салбарын төр, хувийн хэвшлийн байгууллагуудын ажилтнууд, малчин, тариаланч, үйлдвэрлэгч хувь хүмүүс, айл өрх, бүлэг, нөхөрлөлүүдийн жендэрийн ялгаатай хэрэгцээ, тулгамдсан асуудлыг илрүүлж, салбарын бодлого төлөвлөлтөд нэгтгэн шийдвэрлэх нь тэдний ажлын орчин нөхцөл, амьдралын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах төдийгүй тэднээс гарах бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулснаар нийгэм дэх жендэрийн тэгш байдалд хувь нэмэр оруулах арга зам болно.

Улс орнууд жендэрийн бодлогоо хөгжлийн хэрэгцээ, байгаль орчин, нийгэм соёл, эдийн засгийн нөхцөл байдалдаа нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд монгол эмэгтэй эрэгтэйчүүдийн жендэрийн харилцаа бүрдэх түүхэн орчин нөхцөл болох бэлчээрийн мал аж ахуйн онцлог, дэлхийн дунджаас 3 дахин илүү хурдацтай өрнөж буй уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд үйлдвэрлэлээ тогтвортой эрхлэхэд эмэгтэй, эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүд суралцах, түншлэн ажиллах шаардлага салбарын жендэрийн бодлогын онцлог шинжийг тодорхойлж байна. Нөгөө талаас үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах, улмаар соёл уламжлал, үндэстний шинж төрхөө хадгалж үлдэх сорилт тулгарч буй энэ цаг үед төрийн болон хувийн хэвшилд ажиллаж, өрхийн үйлдвэрлэл эрхэлж буй эмэгтэй, эрэгтэйчүүдийн идэвх оролцоо, хариуцлагыг бүх түвшинд сайжруулах, тэднийг чадавхижуулан дэмжих нь хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжилд чухал нөлөөтэй байна.

Салбарын жендэрийн бодлогыг боловсруулахад үндэсний түвшинд жендэрийн асуудлаар хийгдсэн судалгаа шинжилгээний дүн, жендэрийн тэгш байдлыг хангах практик ажлын туршлага болон олон улс дахь жендэрийн бодлого төлөвлөлт арга зүйн орчин үеийн чиг хандлагыг харгалзсан бөгөөд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллагч эмэгтэй, эрэгтэйчүүдийн жендэрийн практик ба стратеги хэрэгцээг тодорхойлох зорилгоор 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 3 дугаар сард хийсэн “Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ”, салбарын удирдах ажилтан, мэргэжилтнүүдийг оролцуулсан 3 удаагийн сэдэвчилсэн хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурласан болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүй, бодлогын орчин үндэсний уламжлалт өв соёл, байгаль орчин ба нийгэм эдийн засгийн шинэ нөхцөл байдалд зохицон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалаар тасралтгүй хөгжиж байгаа нь жендэрийн хувьд эерэг сайн үр нөлөөтэйг оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ харуулсан. Үүнд мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулан эрчимжүүлж, малын чанар, бүтээмжийг сайжруулах, иргэдийн ашиг, орлогыг нэмэгдүүлэх, мөн малчдын үүрэг хариуцлага, нийгмийн үнэ цэн, нэр хүндийг өсгөх өргөн утга агуулгатай Малын генетик нөөцийн тухай хууль, нийт хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин болох Органик хүнсний тухай хууль, ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлж тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулах, таримлын зохистой сэлгээ, тэг элдэншүүлгийн технологийг, үе шаттайгаар нэвтрүүлэх бодлого үйл ажиллагаа, ХАА-н зохистой дадлыг нэвтрүүлэх санаачлага зэргийг онцлон дурьдаж болно. Харин эмэгтэй, эрэгтэйчүүдийн, нийгмийн бүлгүүдийн ухамсартай, хариуцлагатай оролцоог шаардсан дээрх бодлогын зорилтуудыг амжилттай, үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд үндэсний төдийгүй байгууллага нэгжийн түвшний жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээ шаардагдаж байна.

Хүний нөөцийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн суурь болох хүйс болон бусад холбогдох үзүүлэлтээр ангилсан жендэрийн статистик мэдээлэл хангалтгүй байна. ХХААХҮЯ болон түүний харьяа байгууллагуудын нийт 461 төрийн албан хаагчдын 40 хувь нь эмэгтэйчүүд, 60 хувь нь эрэгтэйчүүд, харин удирдах ажилтны 28 хувь нь эмэгтэй, 72 хувь нь эрэгтэй байна. 2011 оны байдлаар¹ нийт ААНБ-ын 32 хувь нь эмэгтэй удирдлагатай, үүнээс мал аж ахуйн салбарын ААНБ-ын 39,3, газар тариалангийн салбарын ААНБ-ын 30,25 хувийг эмэгтэйчүүд удирдаж байгаа нь дэлхийн ихэнх улс орнуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт байна.

Салбарын албан хаагчдын талаарх мэдээллийг цаашид нарийвчлан сайжруулах, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллагсдын талаарх жендэрийн статистик мэдээллийг бүрдүүлэх тогтолцоог баг, сум, хорооноос эхлэн бий болгох, хүний нөөцийн тулгамдсан асуудлын хүрээнд мониторинг хийхэд, мөн салбарын бодлого хөтөлбөрийн хүртээмж, үр өгөөжийг хувь хүнд, гэр бүлд, мөн эмэгтэйчүүдэд, эрэгтэйчүүдийн амьдралд гарсан ахиц дэвшлээр үнэлэхэд туслах жендэрийн багц үзүүлэлтүүдийг салбарын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр боловсруулан ашиглах, ялангуяа хяналт үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Малчдын хүйсийн харьцаа алдагдан залуу малчдын эзлэх хувийн жин буурч, харин хүнсний болон хөнгөн үйлдвэрийн салбарт эмэгтэйчүүд түлхүү ажиллаж, эрэгтэйчүүдийн оролцоо буурч, газар тариалангийн салбарт газар, механикжилтын түвшин, таримлын нэр төрлөөр жендэрийн ялгарал үүсч байгаа зэрэг хүний нөөцийн жендэрийн асуудлыг хүний нөөцийн бодлого төлөвлөлтөд нэгтгэн, нийгэм эдийн засгийн цогц арга хэмжээгээр шийдвэрлэх шаардлагатай байна.

Төр, хувийн хэвшлийн ажиллагсдын хувьд зохистой хөдөлмөрийн орчин нөхцлийг бүрдүүлэх, түүний дотор жендэрт суурилсан ялгаварлан гадуурхал гарахаас сэргийлэх, энэ талаар санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг байгууллага, хамт олны түвшинд бүрдүүлэх ажлыг салбарын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх, ажил-ар гэрийн тэнцвэрийг анхаарсан жендэрт нийцтэй байгууллагын соёлыг хөгжүүлэхэд төрийн албаны манлайллыг сайжруулах шаардлагатай.

Салбарын үйл ажиллагааг илүү хүртээмжтэй, үр өгөөжтэй болгоход жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийн арга зүйг ашиглах боломж байна. Мал аж ахуй, газар тариалан, хүнсний ба хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бодлого, үйл ажиллагааг эмэгтэй, эрэгтэйчүүдэд, нийгмийн бүлгүүдэд хүртээмжтэй, үр өгөөжтэй хүргэх, түүний дотор эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэхдээ эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай ажил үүрэг, ялгаатай хэрэгцээнд суурилсан сургалт, нөлөөллийн шинэлэг, оновчтой арга хэлбэрийг ашиглах асуудал тулгамдаж байна. Эдгээр нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст хүртээмжтэй ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар салбарын тогтвортой хөгжлийг дэмжихэд чухал үүрэгтэй.

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангахад эмэгтэй, эрэгтэй хэрэглэгчдийн ялгаатай үүрэг, хэрэгцээнд нийцсэн нөлөөллийн арга хэрэгслийг ашиглах, мөн үндэсний болон орон нутгийн түвшний түншлэл хамтын ажиллагаа, худалдан авалтаар жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхэлж буй эмэгтэйчүүдийг дэмжих, улмаар эрэгтэйчүүдийн оролцоог сайжруулах боломж байна.

Хүний нөөцийн болон үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөлж буй жендэрийн асуудлыг илрүүлэн шийдвэрлэх салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар идэвхитэй оролцож үндэсний болон олон улсын түвшинд манлайлан ажиллах шаардлага тулгарч байна. Жишээлбэл төрийн үйлчилгээг залуу малчин өрхүүдийг дэмжихүйц байдлаар хүргэх, ялангуяа эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, хөдөөгийн хөгжлийг дэмжсэн, орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн жендэрийн мэдрэмжтэй сургалтын тогтолцоо бий болгох зэрэг олон асуудал салбар хоорондын түншлэл хамтын ажиллагааны хүрээнд шийдлээ хүлээж байна.

¹ Хөдөө аж ахуйн 2011 оны анхдугаар нэгдсэн тооллогын тайлан

Хөдөөгийн хөгжил, аж үйлдвэрийн хөгжлийн хүрээнд ижил төстэй асуудалтай улс орнуудтай туршлага солилцох, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл дэх тогтвортой хөгжил, түүний дотор жендэрийн мэдрэмжтэй бодлогын хөгжлийн асуудлаар, мөн Монгол Улсын санаачилсан “Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах тухай” НҮБ-ийн тогтоолыг хэрэгжүүлэхэд үндэсний болон олон улсын түвшин дэх манлайлан ажиллаж салбарын хөгжлийг дэмжих чадавхи, түншлэл хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй байна.

Зураг 1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн тойрог



Салбарын жендэрийн бодлого нь төр, хувийн хэвшлийн хүний нөөцийг хөгжүүлж, ажилтан албан хаагчдын ажлын орчин нөхцлийг сайжруулахад чиглэхээс гадна төрийн үйлчилгээний хүртээмж, үр өгөөжийг сайжруулах, салбарын тогтвортой хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн бүх түвшин дэх тэгш оролцоо, тэгш хариуцлагын зарчмыг нэвтрүүлж, түншлэл хамтын ажиллагааг үндэсний болон олон улсын түвшинд хөгжүүлэх өргөн хүрээний үйл ажиллагааны стратеги, зураглал болно. Энэхүү бодлого нь мөн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын олон талт түншлэгчдийн жендэрийн асуудалд зарцуулж буй хүний болон санхүүгийн нөөцийг илүү үр бүтээлтэй хуваарилан зарцуулах боломж бүрдүүлэх ба салбарын хүний нөөц болон бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжлийн шинэ шатанд гаргаж, жендэрийн тэгш байдлыг хангахад жинтэй хувь нэмэр оруулахад чиглэгдэнэ.

Хоёр. Эрх зүйн үндэслэл

Салбарын жендэрийн бодлого боловсруулан баталж хэрэгжүүлэх нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг салбарын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх үр өгөөжтэй арга зам бөгөөд салбарын ажилтан албан хаагчдын болон бодлого үйл ажиллагааны ашиг тусыг хүртэгч хүн амын бүлгүүдийн бодит хэрэгцээнд суурилсан, алсын хараат, цогц хандлага юм.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол улсын хуулийн (2011) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи Засгийн газрын бүрэн эрхийн тухай 16-р зүйлийн 16.1.1.-д “жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөр, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, эдгээрийн хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн эх үүсвэрийг батлуулах” гэж заасан байна. Мөн хуулийн 18.3.1-д Жендэрийн үндэсний хороо жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулахаар заасан байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн талаар 19-р зүйлийн 19.1.-д “тухайн салбар, орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх, тэдгээрийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэж, тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах”, 19.1.2.-т “тухайн салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх” талаар заасан байна.

Гурав. Бодлогын зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт үнэлгээгээр дэмжинэ.

.Дөрөв. Бодлогын зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааны чиглэл

Салбарын жендэрийн бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх;

Хүрэх үр дүн: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийх арга хэрэгсэл, мэдлэг чадавхи бүрдэж, жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоо хөгжинэ.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжин жендэрийн тэгш оролцоо, тэгш хариуцлагыг бүх түвшинд нэмэгдүүлэх;

Хүрэх үр дүн: Салбарын ажиллагсдын ажлын орчин нөхцөл, тэдэнд чиглэсэн төрийн үйлчилгээ ба хүний нөөц бэлтгэх тогтолцооны жендэрийн мэдрэмж сайжирч, эмэгтэй, эрэгтэй хүмүүс салбарын хөгжилд хувь нэмэр оруулах боломж, чадавхи сайжирна.

3. Үндэсний ба олон улсын түвшин дэх жендэрийн түншлэл, хамтын ажиллагаагаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих.

Хүрэх үр дүн: ХХААХҮ-ийн салбарт тулгамдаж буй жендэрийн асуудлыг шийдэх салбар дундын зохицуулалт, түншлэл хамтын ажиллагаа үндэсний

болон орон нутгийн түвшинд сайжирч, олон улсын түвшинд салбарын
жөндөрийн асуудлаар манлайлан ажиллах чадавхи бүрдэнэ.

Зорилт 1-ийн хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1. ХХААХҮ-ийн салбарын жөндөрийн бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэх;
- 1.2. ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлтөд жөндөрийн дүн шинжилгээ, жөндөрийн үнэлгээ, жөндөрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх;
- 1.3. ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлт, хяналт үнэлгээнд жөндөрийн статистик мэдээлэл, жөндөрийн шалгуур үзүүлэлтийн ашиглалтыг хэвшүүлэх,
- 1.4. ХХААХҮ-ийн салбарын бүх түвшинд жөндөрт ээлтэй байгууллагын соёлыг бүтээх төрийн албаны манлайллыг хөгжүүлэх.

Зорилт 2-ын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.1. Салбарын төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллагч эмэгтэй, эрэгтэйчүүдийн ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- 2.2. Салбарын хүний нөөцийг бэлтгэх үйл явц, тогтолцоог жөндөрийн мэдрэмжтэй хөгжүүлэх;
- 2.3. Ажлын байранд жөндөрийн ялгаварлан гадуурхлаас сэргийлэх, санал гомдол хүлээн авч шийдвэрлэх, жөндөрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдийг ажлын байранд нь хамгаалах, дэмжих механизмыг төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-уудад бүрдүүлэх;
- 2.4. Малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх;
- 2.5. Хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийн технологи, сургалт, санхүү-зээлийн үйлчилгээг жөндөрийн мэдрэмжтэй хөгжүүлж, эмэгтэйчүүд ажиллах нөхцлийг сайжруулах;
- 2.6. Хөдөө аж ахуйн зохистой дадлыг малчин, тариаланч эмэгтэй, эрэгтэйчүүдийн жөндөрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн эзэмшүүлж, нийгмийн хариуцлагыг нь нэмэгдүүлэх;
- 2.7. ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлд ажиллаж буй эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн орон нутагт суурилсан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, бизнес инкубаторын хүртээмжтэй тогтолцоо бий болгох;
- 2.8. Салбарт ажиллагч эмэгтэй, эрэгтэйчүүдийн жөндөрийн ялгаатай хэрэгцээг хангаж, тэгш оролцоог дэмжих орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагчдын чадавхийг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх.

Зорилт 3-ын хүрээнд дараах чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. ХХААХҮ-ийн салбарт жөндөрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг дэмжих;
- 3.2. Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолын хэрэгжилтийг үндэсний болон бүс нутгийн түвшинд манлайлах чадавхийг бэхжүүлэх;
- 3.3. Бүх түвшний хэрэглэгчдийн жөндөрийн ялгаатай үүрэг ба хэрэгцээнд тулгуурлан үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, зохистой хэрэглээг төлөвшүүлэх үндэсний чадавхийг хөгжүүлэх;
- 3.4. ХХААХҮ-ийн салбарт жөндөрийн тэгш байдлыг хангахад донор орнууд, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа, үр өгөөжийг сайжруулах.

Тав. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа

Бодлогыг 2018-2025 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Эхний үе шат буюу 2018-2021: Энэ үе шат нь Засгийн газраас 2017-2021 онд хэрэгжүүлэх “Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны хэрэгжилттэй уялдана.

Хоёрдахь үе шат буюу 2022-2025: Энэ үе шат нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ийн хэрэгжилттэй уялдана.

Зургаа. Бодлогыг хэрэгжүүлэх төсөв, хөрөнгийн эх үүсвэр

Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- Хандивлагч улс, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;
- Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;
- Бусад.

Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр нарийвчлан гаргаж, голлон хэрэгжүүлэгч болон оролцогч талуудыг тодорхойлж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх олон улсын болон бусад байгууллагуудын салбарын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, дэмжлэгийнхээ хоёроос доошгүй хувийг тус бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах зохицуулалтыг бий болгон хэрэгжүүлнэ.

Долоо. Удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Бодлогын хэрэгжилтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дахь Жендэрийн Үндэсний Хорооны салбар зөвлөл удирдан зохион байгуулна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэнд байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хяналт-шинжилгээний дүнг Жендэрийн салбар зөвлөл хэлэлцэн, салбарын холбогдох бодлого төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагаанд тусгана. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу бодлогын хэрэгжилтийг Жендэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 02 дугаар сарын 20-нд багтаан тайлагнана.

Бодлогын эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг 2022 оны эхний улиралд багтаан үнэлж, хоёрдугаар шатанд авах арга хэмжээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

—o0o—

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын талаар баримтлах бодлогыг (2018-2025) хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, үе шатаар

Зорилго: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт үнэлгээгээр дэмжинэ.

Зорилт	Хүрэх үр дүн	Үйл ажиллагааны чиглэл	I үе шат: 2018-2021		II үе шат: 2022-2025	
			Үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд	Үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд
1. Салбарын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг дэмжих жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийх арга хэрэгсэл, мэдлэг чадавхи бүрдэж, жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоо хөгжинэ.	1. ХХААХҮ-ийн салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэх;	<ol style="list-style-type: none"> Жендэрийн бодлого, жендэрийн салбар зөвлөлийг (ЖСЗ) танилцуулах мэдээлэл сурталчилгааг салбар, байгууллага, нэгжүүдийн вэб хуудсанд байршуулах, Жендэрийн бодлогыг танилцуулах семинарыг үе шаттай, хүртээмжтэй зохион байгуулах болон салбарын удирдах ажилтны жил бүрийн зөвлөгөөн, байгууллагуудын мэдээллийн цагаар сурталчлах, бодлогын хэрэгжилтийн явцыг танилцуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ЖСЗ-ийг салбарын мэргэжилтнүүдийг оролцуулан, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18.1-д зааснаар төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын тэнцүү оролцоог хангасан байдлаар өргөтгөх, Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд ЖСЗ-ийн гишүүдийн гүйцэтгэх үүргийг ялгамжтай тогтоож үр дүнгийн гэрээнд нь тусгах, ЖСЗ-ийн дүрэмд жендэрийн бодлого төлөвлөлтийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд тогтвортой дэмжлэг үзүүлэх талаар тодорхой тусган шинэчлэх, дүрмийн хавсралтанд салбар, орон нутгийн түвшинд шинээр хэрэгжих төсөл хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх нийтлэг шалгуур үзүүлэлтүүдийг оруулан батлах, Харьяа агентлаг, аймгуудын ХХААГ, сумын ХХАА-ын тасагт жендэрийн асуудлыг ажилтнууд сэлгээгээр хариуцан ажиллах удирдамж боловсруулж сонгосон агентлаг, орон нутгийн байгууллагад турших, ХХААГ-т жендэрийн асуудал хариуцаж буй мэргэжилтнийг аймгуудын жендэрийн салбар хорооны (ЖСХ) бүрэлдэхүүнд оруулах зохицуулалт хийх, 	<ul style="list-style-type: none"> Салбарын жендэрийн бодлогыг вэб хуудсандаа байршуулсан байгууллагын тоо, Жендэрийн бодлого, түүний хэрэгжилтийн явцыг танилцуулсан арга хэмжээнд хамрагдсан ажилтнуудын тоо, байгууллага, хүйсээр, Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар үр дүнгийн гэрээнд тусгасан ЖСЗ-ийн гишүүдийн тоо, ЖСЗ-ийн бүрэлдэхүүн, төсөл хөтөлбөрийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх нийтлэг шалгуур үзүүлэлтүүдийн хамт шинэчлэн баталсан ЖСЗ-ийн дүрэм, Жендэрийн асуудлыг сэлгэн хариуцсан ажилтнуудын тоо, байгууллага, хүйсээр, ЖСХ-ны бүрэлдэхүүнд орсон ХХААХҮ-ийн салбарын ажилтны тоо, хүйсээр 	<ol style="list-style-type: none"> Жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцыг салбарын удирдах ажилтны жил бүрийн зөвлөгөөн, байгууллагуудын мэдээллийн цагаар мэдээлэх, тайлагнах ажлыг тогтмолжуулах, ХХААХҮ-ийн салбарын үйл ажиллагааны чиглэлүүдийн жендэрийн агуулгыг тодорхойлон зэрэглэж, жендэрийн тэгш байдлыг хангах үүрэг хариуцлагыг ажлын байртай холбон хуваарилах, Харьяа агентлаг, аймгуудын ХХААГ, сумын ХХАА-ын тасагт жендэрийн асуудлыг ажилтнууд сэлгээгээр хариуцан ажиллах удирдамжийг бүх түвшинд хэрэгжүүлэх зохицуулалтыг хийх, ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв (<i>Agriculture extension service centre</i>) -ийн зөвлөхүүд, ЖДҮ-ийн зөвлөх, салбарын ахмад шинжээчдээр жендэрийн сургагч багш нарын баг бүрдүүлэн сургах, ЖСЗ-ийн гишүүд болон агентлаг, байгууллагад жендэрийн асуудлаар ажиллах ажилтнуудын сургалт, мэргэжил арга зүйн дэмжлэг авах хэрэгцээг судлан дараагийн шатны жендэрийн бодлого төлөвлөлтөд тусгах, 	<ul style="list-style-type: none"> Жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцыг мэдээлэх, тайлагнах арга хэмжээг тусгасан төлөвлөгөө, Жендэрийн бодлогын хэрэгжилтийн явцыг мэдээлсэн, тайлагнасан арга хэмжээний тоо, Жендэрийн тэгш байдлыг хангах үүрэг хариуцлага хүлээсэн ажилтны тоо, байгууллага, хүйсээр Жендэрийн асуудлыг сэлгэн хариуцсан ажилтнуудын тоо, байгууллага, хүйсээр, Жендэрийн сургагч багш болсон салбарын ажилтнуудын тоо, хүйсээр ЖСЗ-ийн гишүүд, агентлаг, байгууллагын жендэрийн асуудал хариуцсан ажилтнуудын сургалт, мэргэжил арга зүйн дэмжлэгийн хэрэгцээг тодорхойлсон судалгааны тайлан, зөвлөмж.

	<p>2. ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлтөд жендэрийн дүн шинжилгээ, үнэлгээ, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүй, нэвтрүүлэх;</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн төсөлд жендэрийн үнэлгээ хийх аргачлалыг ХХААХҮ-ийн салбарт нэвтрүүлж хэрэглэх, 2. Бэлчээрийн тухай хуулийн төсөлд жендэрийн үр нөлөөний үнэлгээ хийх, 3. ЖДҮ болон мал аж ахуй, газар тариалангийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого, үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчдад зөвлөмж хүргүүлэх, 4. Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ-ийг дэмжих сангийн төсөвт жендэрийн дүн шинжилгээ хийж жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох, 5. Дэд салбар бүрт сонгогдсон байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрэглэгчдээс авах жендэрийн мэдрэмжтэй судалгаа хийх, үр дүнг шинжлэх, тайлагнах, 6. Салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд мөн ядуурлын эсрэг, нийгмийн оролцоот ногоон хөгжлийн хандлагыг нэвтрүүлэх бодлогын арга хэмжээг тодорхойлох хэлэлцүүлэг хийх, 	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн үнэлгээ хийгдсэн хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн төслийн тоо, • Бэлчээрийн тухай хуулийн төсөлд хийсэн жендэрийн үр нөлөөний үнэлгээний тайлан, зөвлөмж • ЖДҮ-г дэмжих бодлого, үйл ажиллагаанд хийсэн жендэрийн дүн шинжилгээний тайлан • Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ЖДҮ-ийг дэмжих сангийн төсөвт хийсэн жендэрийн дүн шинжилгээний тайлан, • Хэрэглэгчдээс судалгаа авч, үр дүнг хүйс, бусад үзүүлэлтээр ангилан шинжилсэн байгууллагын тоо, хамрагдсан хэрэглэгчдийн тоо • Салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд мөн ядуурлын эсрэг, нийгмийн оролцоот ногоон хөгжлийн хандлагыг нэвтрүүлэх бодлогын арга хэмжээг тодорхойлох хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, байгууллагаар. 	<ol style="list-style-type: none"> 1. Шинээр боловсруулсан хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийн төсөлд жендэрийн үнэлгээ хийж хэвших, 2. Малчин эмэгтэй эрэгтэйчүүдийн амьдралын хэв маяг, нийгмийн идэвхи оролцоо, ирээдүйн төлөвлөгөөнд гарч буй өөрчлөлтийг орон нутаг бүрээр тогтмол судлан мал аж ахуйн салбарын бодлого төлөвлөлтөд нэгтгэх ажлыг эхлүүлэх ,/бэлчээрийн үр нөлөө / 3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг салбарын сонгосон байгууллагуудад туршин нэвтрүүлэх, 4. ЖДҮ-д олгох санхүүгийн дэмжлэгийг хүртээмжтэй, тэгш шударга бөгөөд орон нутгийн, эмэгтэй эрэгтэйчүүд, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн байдлаар хүргэх оновчтой тогтолцоог олон талын оролцоотой тодорхойлон эрх зүйн орчныг бүрдүүлэх, 5. Малчин, фермер, газар тариалан эрхлэгч өрхүүдийн хувийн хэрэгцээний газар өмчлөл, бэлчээрийн болон газар тариалангийн зориулалтын газрын эзэмшилт, өвөлжөө, хаваржаа, уст цэгийн эзэмшилтийн байдалд жендэрийн дүн шинжилгээ хийх. 	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн үнэлгээ хийгдсэн хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн төслийн тоо, • Малчин эмэгтэй эрэгтэйчүүдийн амьдралын хэв маяг, нийгмийн идэвхи оролцоо, ирээдүйн төлөвлөгөөнд гарч буй өөрчлөлтөд хийсэн судалгааны тайлан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, • Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга зүйг ашигласан салбарын байгууллагын тоо, дэд салбар тус бүрээр, • ЖДҮ-д олгох санхүүгийн дэмжлэгийг хүртээмжтэй, шударга хуваарилах талаар гаргасан эрх зүйн зохицуулалт, • Санхүүгийн дэмжлэг хүртсэн ЖДҮ эрхлэгчдийн тоо, хүйсээр, орон нутгаар, үйл ажиллагааны чиглэлээр, • Малчин, фермер, газар тариалан эрхлэгч өрхүүдийн газар өмчлөл, эзэмшилт, уст цэгийн эзэмшилтэд хийсэн дүн шинжилгээний тайлан, зөвлөмж.
	<p>3. ХХААХҮ-ийн салбарын бодлого төлөвлөлт, хяналт үнэлгээнд жендэрийн статистик мэдээлэл, жендэрийн шалгуур үзүүлэлтийн ашиглалтыг хэвшүүлэх;</p>	<ol style="list-style-type: none"> 1. Салбарын бүх тайлан мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, хяналт үнэлгээний тайлангуудад хүнтэй холбоотой мэдээллийг хүйсээр ангилан харуулж байх чиглэл өгөх, 2. Салбарын төрийн байгууллагын дотоод хяналт үнэлгээнд хүний нөөцийн хүйсээр ангилсан мэдээллийн багц үзүүлэлтийг ²нэвтрүүлэх , 3. Салбарын төрийн албан хаагчид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллагчдын талаарх мэдээлэл цуглуулах, тайлагнахад бүх 	<ul style="list-style-type: none"> • Салбарын танилцуулга, үйл ажиллагааны тайлан дахь хүний нөөцийн мэдээлэлд хүйсээр ангилагдсан мэдээллийн эзлэх хувь, • Дотоод хяналт үнэлгээнд хүйсээр ангилсан мэдээллийн багц үзүүлэлт ашиглаж буй байгууллагын тоо, дэд салбараар, • Жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлт ашиглан хийсэн ажлын байрны зураг 	<ol style="list-style-type: none"> 1. ХХААХҮ салбар дахь жендэрийн нөхцөл байдалд мониторинг хийхэд шаардагдах үзүүлэлтүүдийг салбарын үйл ажиллагааны чиглэл бүрээр шинэчлэн тодорхойлж ҮСХ-ны мэдээлэлд нэгтгэх ажлыг тогтмолжуулах, 2. ХХААХҮ-ийн салбарт ажиллагчдын ажлын орчин нөхцлийг үнэлэх ажлын байрны зураг авалтад ашиглах жендэрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтүүдийг салбарын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр, байгууллагын хүчин чадлаас хамааран 	<ul style="list-style-type: none"> • Салбарын танилцуулга, үйл ажиллагааны тайлан дахь хүний нөөцийн мэдээлэлд хүйсээр ангилагдсан мэдээллийн эзлэх хувь • ҮСХ-ны мэдээллийн тогтолцоонд ХХААХҮ-ийн салбарын хүний нөөцийн талаар ашиглаж буй үзүүлэлтийн тоо, • Ажилтнуудын ажлын ачааллын хуваарилалтыг хяналт үнэлгээний тогтолцоонд үзүүлэлт болгон

² Жишээ нь эмэгтэй эрэгтэй ажилтнуудын цалин хөлс, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалт, мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдалт, шагнал урамшуулал авсан байдал, томилолтоор ажилласан байдал, ажлын цагийн ачаалал, илүү цагаар ажилласан байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, хүүхдээ ганцаар өсгөж буй эцгүүдийн тоо гэх мэт.

		<p>түвшинд ашиглаж буй маягтуудыг жөндөрийн мэдрэмжтэй болгох,</p> <p>4. ХХААХҮ-ийн салбарт ажиллагчдын ажлын орчин нөхцлийг үнэлэх ажлын байрны зураг авалтад ашиглах жөндөрийн мэдрэмжтэй шалгуур үзүүлэлтүүдийг ХХААХҮЯ, түүний харьяа агентлаг байгууллагуудад зориулан боловсруулж турших,</p> <p>5. ХХААХҮ салбар дахь жөндөрийн нөхцөл байдалд мониторинг хийхэд шаардагдах үзүүлэлтүүдийг³ салбарын үйл ажиллагааны чиглэл бүрээр гаргаж ҮСХ-ны мэдээллийн тогтолцоотой уялдуулах,</p> <p>6. ХХААХҮ-ийн салбарын үйл ажиллагааны чиглэл тус бүрийн онцлогт нийцсэн жөндөрийн хяналтын хуудсыг төрийн үйлчилгээ, салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгцээнд нийцүүлэн боловсруулан туршиж нэвтрүүлэх,</p>	<p>авалтын тоо, дэд салбараар, байгууллагаар,</p> <ul style="list-style-type: none"> • ҮСХ-ны мэдээллийн тогтолцоонд ХХААХҮ-ийн салбарын хүний нөөцийн талаар ашиглаж буй үзүүлэлтийн тоо, • Жөндөрийн хяналтын хуудсыг туршсан байгууллага, төслийн тоо, 	<p>ялгавартай боловсруулж туршин нэвтрүүлэх,</p> <p>3. ХХААХҮЯ, түүний харьяа төрийн байгууллагын ажилтнуудын ажлын ачааллыг ажлын байрны тодорхойлолтын дагуу тэнцвэртэй хуваарилсан байдлыг хяналт үнэлгээний тогтолцоонд үзүүлэлт болгон оруулах,</p> <p>4. Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн үнэлгээнд хувь хүн, айл өрхөд гарсан өөрчлөлтийг хэмжих жөндөрийн мэдрэмжтэй үзүүлэлтүүдийг нэвтрүүлэх боломжийг судлан түншлэлийн хүрээнд хэлэлцүүлэх.</p>	<p>ашиглаж буй байгууллагын эзлэх хувь,</p> <ul style="list-style-type: none"> • Хувь хүн, айл өрхөд гарсан өөрчлөлтийг хэмжих жөндөрийн мэдрэмжтэй үзүүлэлтүүдийг нэвтрүүлэхэд чиглэсэн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Хүйсээр ангилсан мэдээллийг үндэслэл болгон ашигласан бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрийн тоо,
4. ХХААХҮ-ийн салбарын бүх түвшинд жөндөрт ээлтэй байгууллагын соёлыг бүтээх төрийн албаны манлайллыг хөгжүүлэх;	<p>1. Удирдах ажилтнуудад зориулсан жөндөрийн цахим сургалтын хөтөлбөрийг салбарын үйл ажиллагаанд нийцүүлэн нэвтрүүлэх,</p> <p>2. ХХААХҮЯ-ны сайд аймгийн Засаг дарга нар, байгууллагын удирдлагуудтай байгуулах үр дүнгийн гэрээнд салбарын жөндөрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах талаар заалт оруулах,</p> <p>3. Ажлын орчин нөхцөл, ажил-ар гэрийн тэнцвэрийн талаар санал хүсэлт гаргах, хамтран шийдвэрлэх нээлттэй, найрсаг, харилцан итгэлцсэн уур амьсгал, соёлыг бий болгох чиглэлээр олон улсын туршлагыг судлан нэвтрүүлэх,</p> <p>4. ХХААХҮ-ийн салбарын удирдах ажилтнуудад жөндөрт ээлтэй байгууллагын соёлыг хөгжүүлэхэд зориулсан зөвлөмж боловсруулан хүргэх,</p> <p>5. Салбарын орон тооны бус бүх зөвлөл, салбар хороодын гишүүдийн хүйсийн тэнцвэрийг сайжруулах,</p> <p>6. Төрийн байгууллагууд ажилтнуудаас жөндөрийн нөхцөл байдлыг</p>	<ul style="list-style-type: none"> • Жөндөрийн цахим сургалтад хамрагдсан салбарын удирдах ажилтны тоо, хүйсээр, дэд салбараар, байршлаар, • Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээн дэх жөндөрийн агуулга, • Жөндөрт ээлтэй байгууллагын соёлыг бий болгох олон улсын туршлагыг судалсан үр дүнгийн хэлэлцт оролцогчдын тоо, хүйсээр, • Жөндөрт ээлтэй байгууллагын соёлыг хөгжүүлэх талаар зөвлөмж хүргэсэн удирдах ажилтны тоо, хүйсээр, дэд салбараар, • ХХААХҮ-ийн салбарын орон тооны бус зөвлөл, хороодын нийт гишүүдийн хүйсийн харьцаа, • Сэтгэл ханамжийн судалгааг жөндөрийн мэдрэмжтэй байдлаар авч хүний нөөцийн бодлого төлөвлөлтөд 	<p>1. Жөндөрт ээлтэй, олон янз байдлыг дэмжсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудад зөвлөн ажиллах боломжтой албан хаагчдыг салбарын үйл ажиллагааны чиглэл, түвшин бүрт тодорхойлон сургалтад хамруулж, чиглэл удирдамж өгөх</p> <p>2. Орон нутагт ажиллах албан хаагчдын гэр бүлийн гишүүдийг ажлын байраар хангах, хүүхдүүдийг сургууль цэцэрлэгт хамруулах нөөц боломжийг судлан, холбогдох зохицуулалтыг хийх,</p> <p>3. Ажлын орчин нөхцөл, ажил-ар гэрийн тэнцвэрийн талаар санал хүсэлт гаргах, хамтран шийдвэрлэх нээлттэй, найрсаг, харилцан итгэлцсэн уур амьсгал, соёлыг бий болгох чиглэлээр олон улсын туршлагыг судлан нэвтрүүлэх,</p> <p>4. Жөндөрийн мэдрэмжтэй байгууллагын соёлыг бүрдүүлсэн байгууллага, удирдах ажилтныг шалгаруулан сурталчилж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх</p> <p>5. Салбарын төрийн албанд ажиллаж буй бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд</p>	<ul style="list-style-type: none"> • ХХААХҮ-ийн салбарын орон тооны бус зөвлөл, хороодын нийт гишүүдийн хүйсийн харьцаа, • Хувийн хэвшлийн байгууллагуудад жөндөрт ээлтэй байгууллагын соёлын асуудлаар зөвлөх ур чадвар эзэмшсэн албан хаагчдын тоо, хүйсээр, дэд салбараар, • Орон нутагт гэр бүлийн гишүүдийг нь ажлын байраар хангасан, хүүхдүүдийг нь сургууль цэцэрлэгт хамруулсан албан хаагчдын тоо, албан тушаалаар, хүйсээр • Жөндөрийн мэдрэмжтэй байгууллагын соёлыг бүрдүүлэн шалгарсан байгууллагын тоо дэд салбараар, удирдах ажилтны тоо, хүйсээр • Бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан ажлын уян хатан цагийн зохицуулалтыг туршин 	

³ Жишээ нь залуу малчдын хүйсийн харьцаа, малчдын боловсролын байдал хүйсээр, фермерийн аж ахуйд ажиллагсдын хүйсийн харьцаа, аж ахуйн чиглэлээр, газар тариалангийн салбарт улирлаар болон түр ажиллаж буй хүмүүсийн хүйсийн харьцаа, салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх эзэл тусламжид хамрагдагчдын хүйсийн харьцаа үйл ажиллагааны чиглэлээр гэх мэт.

			<p>тодруулахуйц байдлаар боловсруулсан⁴ асуулгаар сэтгэл ханамжийн судалгааг авч хүйсээр ангилан шинжилж байгууллагын хүний нөөцийн бодлого төлөвлөлтөд ашиглах,</p> <p>7. Ажил мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг асуудлаар ажилтнуудаас санал авах замаар тодорхойлсон хэрэгцээнд үндэслэн сургалтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх,</p>	<p>ашигласан байгууллагын тоо, дэд салбараар,</p> <ul style="list-style-type: none"> • Сургалтын хэрэгцээг ажилтнуудаас судалгаа авч тодорхойлон төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байгууллагын тоо. 	<p>зориулсан ажлын уян хатан цагийн зохицуулалтыг туршин нэвтрүүлэх,</p> <p>8. Төрийн албан хаагчдын тогтвортой ажиллах, хөгжих боломжоор хангах, эмэгтэйчүүд удирдах албан тушаалд дэвшин ажиллах боломжийг нэмэгдүүлэх мерит зарчмыг хэрэгжүүлэхэд ХХААХҮ-ийн салбарын төрийн албаны салбар зөвлөл (ТАСЗ) ба ЖСЗ-ийн хамтарсан төлөвлөгөө гарган баталж хэрэгжүүлэх,</p> <p>6. Зэрэг дэв, цалин урамшууллын нэмэгдэл, гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх, туршлах судлах сургалтын талаарх мэдээллийг бүх ажилтанд ил тод болгох талаар хөдөлмөрийн дотоод журамд тусгах,</p>	<p>нэвтрүүлсэн байгууллагын тоо, байршлаар</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн албанд мерит зарчмыг хэрэгжүүлэх чиглэлээр ТАСЗ ба ЖСЗ-ийн хамтарсан төлөвлөгөөний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, • Зэрэг дэв, цалин урамшууллын нэмэгдэл, гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх, туршлах судлах сургалтын талаарх мэдээллийг ил тод болгосон байгууллагын тоо,
<p>2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжин жендэрийн тэгш оролцоо, тэгш хариуцлагыг бүх түвшинд нэмэгдүүлэх;</p>	<p>Салбарын ажиллагчдын ажлын орчин нөхцөл, тэдэнд чиглэсэн төрийн үйлчилгээ ба хүний нөөц бэлтгэх тогтолцооны жендэрийн мэдрэмж сайжирч, эмэгтэй эрэгтэй хүмүүс салбарын хөгжилд хувь нэмэр оруулах боломж, чадавхи сайжирна</p>	<p>1. Салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн ХАБЭА, нийгмийн хамгааллыг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;</p>	<p>1. Салбар дахь зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн асуудлаар цуврал сургалт, семинарыг ҮЭ, ОУХБ-тай хамтран зохион байгуулах,</p> <p>2. Ажлын орчин нөхцлийг жендэрийн мэдрэмжтэй үнэлж судлах шаардлагатай чиглэлүүдийг салбарын хэмжээнд тодорхойлж судалгаа хийх,</p> <p>3. Хүнсний болон хөнгөн үйлдвэрийн салбарын эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын хувьд мөрдөгдөх жендэрийн мэдрэмжтэй зохистой хөдөлмөрийн орчин нөхцөлийн жишиг шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж, төр, хувийн хэвшлийн ажил олгогчид, ажилчдад танилцуулан, ХАБ, МХЕГ-ийн хяналт үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх,</p> <p>4. Туслах малчдын нөхцөл байдлын судалгааг жендэрийн мэдрэмжтэй хийж, нийгмийн хамгааллын арга хэмжээний хэрэгцээг тодорхойлох,</p> <p>5. Салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд ХАБЭА-н асуудлыг тусгаж хэрэгжүүлэх,</p> <p>6. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад түр гэрээгээр ажиллаж буй мэргэжлийн ба мэргэжлийн бус</p>	<ul style="list-style-type: none"> • Салбар дахь зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн асуудлаар зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдагчдын тоо, хүйсээр, дэд салбараар, • Ажлын орчин нөхцлийн талаар жендэрийн мэдрэмжтэй хийгдсэн судалгааны тоо, тайлангийн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Хүнсний болон хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн мэдрэмжтэй зохистой хөдөлмөрийн орчин нөхцөлийн жишиг шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хийсэн ХАБ, МХЕГ-ийн хяналт үнэлгээний тоо, • Туслах малчдын нөхцөл байдлын судалгааны тайлангийн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр • Хөдөлмөрийн дотоод журамд ХАБЭА-н асуудлыг тусгаж хэрэгжүүлсэн байгууллагын 	<p>1. Жендэрийн мэдрэмжтэй судалгааны үр дүнд тулгуурлан зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүдийг салбарын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гаргах,</p> <p>2. Салбар дахь зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн асуудлаар цуврал сургалт, семинарыг ҮЭ, ОУХБ-тай хамтран үргэлжлүүлэн зохион байгуулах,</p> <p>3. Салбарын төрийн захиргааны төв байгууллага, харьяа агентлаг, байгууллагуудын төрийн үйлчилгээний эрэгтэй, эмэгтэй ажилтнуудад тусдаа өрөө бий болгох,</p> <p>4. Ажлын орчин нөхцлийг жендэрийн мэдрэмжтэй үнэлж судлах шаардлагатай чиглэлүүдийг салбарын хэмжээнд тодорхойлж судалгаа хийх,</p> <p>5. Газар тариалангийн салбарт ажиллагчдын тэтгэвэр тогтоох нөхцлийг судлан хэлэлцүүлэг зохион байгуулах,</p> <p>6. Салбарын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд ХАБЭА-н асуудлыг тусгаж хэрэгжүүлэх,</p> <p>7. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад түр гэрээгээр ажиллаж</p>	<ul style="list-style-type: none"> • Зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүд гаргасан үйл ажиллагааны чиглэлийн тоо, • Салбар дахь зохистой хөдөлмөр эрхлэлтийн орчин нөхцөл, хүний нөөцийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийн асуудлаар зохион байгуулсан сургалт, семинарт хамрагдагчдын тоо, хүйсээр, дэд салбараар • Үйлчилгээний эрэгтэй, эмэгтэй ажилтнуудад тусдаа өрөө бий болгосон байгууллагын тоо • Ажлын орчин нөхцлийн талаар жендэрийн мэдрэмжтэй хийгдсэн судалгааны тоо, • Газар тариалангийн салбарт ажиллагчдын тэтгэвэр тогтоох нөхцлийн талаарх хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Хөдөлмөрийн дотоод журамд ХАБЭА-н асуудлыг тусгаж хэрэгжүүлсэн байгууллагын эзлэх хувь, төр, хувийн хэвшлээр

⁴ Энд удирдах, гүйцэтгэх ажилтны харилцаагаар хязгаарлагдахгүй, нас, хүйс, ажлын туршлага зэргээс үүдэн ямар нэг ялгаварлал, зөрчил, сэтгэл дундуур байдал байгаа эсэхийг, мөн ажлын өрөө тасалгааны зохион байгуулалт, хуваарилалтын талаар ажилтнуудын санал бодлыг авахад анхаарах

		<p>эмэгтэй эрэгтэй ажиллагчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч ажиллуулах тогтолцоог бүрдүүлэх,</p> <p>7. Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, эрүүл мэндийн үзлэг үйлчилгээ, ажлын орчинд байрлан амьдрах сууц, хоол тэжээлийн талаар аж ахуйн нэгжүүд нийтээр мөрдөх хэм хэмжээ тогтоох,</p> <p>8. “Хөдөө аж ахуйн зарим механикжсан ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г газар тариалангийн жижиг аж ахуйн нэгж байгууллагууд, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд тохирсон, хүртээмжтэй байдлаар түгээх⁵</p> <p>9. Цэцэрлэг, сургууль, эмнэлгийн тогооч нарын ажлын нормыг тогтоох,</p> <p>10.Цэцэрлэг, сургууль, эмнэлгийн тогооч нарын багаж хэрэгслийг сайжруулах, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр хангах, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах зардлыг байгууллагын төсвөөс гаргаж байх зохицуулалт хийх,</p>	<p>эзлэх хувь, төр, хувийн хэвшлээр,</p> <ul style="list-style-type: none"> •Эмэгтэй, эрэгтэй ажиллагчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч ажиллуулж буй хувийн хэвшлийн байгууллагын эзлэх хувь, •Газар тариалангийн салбарт ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан аж ахуйн нэгжийн эзлэх хувь •“Хөдөө аж ахуйн зарим механикжсан ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгааг хүлээн авсан аж ахуйн нэгж байгууллага, өрхийн үйлдвэрлэгчдийн эзлэх хувь, •Цэцэрлэг, сургууль, эмнэлгийн тогооч нарын ажлын норм тогтоосон эрх зүйн зохицуулалт, 	<p>буй мэргэжлийн ба мэргэжлийн бус эмэгтэй, эрэгтэй ажиллагчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч ажиллуулах тогтолцоог сайжруулах,</p> <p>8. Хөдөлмөрийн хүнд, халуун, хортой нөхцлийн талаар мөрдөгдөж буй жагсаалтыг жендэрийн өнцгөөс үнэлж, шинэчлэх,</p> <p>9. Ажлын орчин нөхцөл эмэгтэй эрэгтэй хүмүүсийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг үйлдвэрлэлийн салбар, чиглэл, шат дамжлага бүрээр судалж, эрүүл мэндийн аливаа эрсдэлийг илрүүлэн сэргийлэх чиглэлээр холбогдох талуудад сургалт хийх.</p> <p>10. ААНБ-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд газар тариалангийн салбарт ажиллагчдыг хүйтний улиралд шилжүүлэн ажиллуулах ажлын байр бий болгох, эсвэл зуучлахад урамшуулах эдийн засгийн хөшүүргийг бий болгох,</p> <p>11. Эмэгтэй эрэгтэй ажиллагчдад тэгш боломж бүрдүүлж, ажилчдын хүүхдэд зориулсан цэцэрлэг байгуулах зэргээр ажил-ар гэрийн тэнцвэрийг хангасан байгууллага шалгаруулан, урамшуулан, хэвлэл мэдээллээр сурталчлах.</p>	<ul style="list-style-type: none"> • Ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч ажиллуулж буй хувийн хэвшлийн байгууллагын эзлэх хувь, • Ажлын орчин нөхцөл дэх эмэгтэй эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлон сэргийлэх чиглэлээр сургалтад хамрагдсан байгууллагын тоо, оролцогчдын тоо, хүйсээр, • Хүйтний улиралд ажлын байраар хангагдсан газар тариалангийн салбарын ажилчдын тоо, хүйсээр, • Ажил-ар гэрийн тэнцвэрийг хангасан байгууллагыг сурталчилсан үйл ажиллагааны тоо .
2. Салбарын хүний нөөцийг бэлтгэх үйл явц, тогтолцоог жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэх;	<p>1. Орон нутгийн сонгосон МСҮТ-үүдэд малчин эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, аж ахуйгаа уур амьсгалын өөрчлөлт, даяаршлын эрин үед хөтлөн явуулах ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг орон нутгийн онцлогт нийцсэн байдлаар туршин нэвтрүүлэх,</p> <p>2. Салбарын хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг дэд салбар тус бүрээр гаргаж, холбогдох сургалтын байгууллагуудад тогтмол мэдээлэх,</p> <p>3. Хүнсний болон хөнгөн үйлдвэрийн мэргэжлээр суралцагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор охид хөвгүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгоход боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх,</p>	<ul style="list-style-type: none"> • Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдэд зориулсан жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөрийг туршсан МСҮТ-ийн тоо, суралцагчдын тоо, хүйсээр, • Салбарын хүний нөөцийн хэрэгцээний тайлан мэдээ хүргэсэн боловсролын байгууллагын тоо, , • Хүнсний болон хөнгөн үйлдвэрийн мэргэжлээр суралцагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн ажлын тоо, 	<p>1. Салбарт ажиллах мэргэжилтнүүдийг байгууллага, орон нутаг, аж ахуйн нэгжийн захиалгаар сургах хэлбэрт сургалтын тогтолцоог шилжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,</p> <p>2. Суралцагчдыг дадлагажуулах аж ахуйн нэгж байгууллагуудыг сонгон чадавхижуулж, дадлагын орчин нөхцлийг жендэрийн мэдрэмжтэй бүрдүүлэх,</p> <p>3. Салбарын мэргэжлүүдээр суралцагчдад бизнесийн удирдлага, ёс зүйн, харилцааны, байгууллагын соёлын чиглэлээр боловсрол олгох, түүний дотор жендэрийн агуулгыг тусгах.</p> <p>4. Орон нутгийн МСҮТ-үүдэд малчин эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай</p>	<ul style="list-style-type: none"> • Байгууллага, орон нутаг, аж ахуйн нэгжийн захиалгаар салбарын мэргэжлээр суралцагчдын эзлэх хувь, хүйсээр, дэд салбараар, • Суралцагчдыг дадлагажуулах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо, дэд салбараар • Бизнесийн удирдлага, ёс зүй, харилцаа, байгууллагын соёл, жендэрийн агуулгыг нэвтрүүлсэн сургалтын хөтөлбөрийн тоо, • Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр бүхий МСҮТ-ийн тоо, 	

⁵ эмэгтэйчүүдийн хөдөлмөртэй холбоотой хориглох зүйлс, жишээлбэл өргөх зөөх ачааны хэмжээг, мөн хүүхдийг эрсдэл, осол гэмтлээс сэргийлэх талаар тусгах

			4. Салбарын мэргэжилтнүүдийн давтан сургалт болон шаталсан сургалтын төлөвлөгөөг хүний нөөцийн хүйсээр ангилсан мэдээлэлд тулгуурлан гаргаж хэрэгжүүлэх,	<ul style="list-style-type: none"> • Давтан сургалт, шаталсан сургалтад хамрагдагчдын тоо, хүйсээр, дэд салбараар, 	хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг бий болгох, 5. Салбарт ажилд шинээр орж буй ажилтнуудад зориулсан танилцуулах сургалтад жендэрийн агуулгыг тусгах.	<ul style="list-style-type: none"> • Шинээр ажилд орж буй ажилтнуудад зориулсан хөтөлбөр дэх жендэрийн агуулга.
	3. Ажлын байранд жендэрийн ялгаварлан гадуурхлаас сэргийлэх, санал гомдол хүлээн авч шийдвэрлэх, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдийг ажлын байранд нь хамгаалах, дэмжих механизмыг төрийн болон хувийн хэвшлийн ААНБ-уудад бүрдүүлэх;	1. Аж ахуйн нэгж, байгууллагууд жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, ЖСЗ-д тайлагнах удирдамжийг байгууллага, аж ахуйн нэгжийн өмчийн хэлбэр, хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийн онцлогийг тусгасан байдлаар ялгавартай боловсруулан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэн турших, 2. Ялгаварлан гадуурхал, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдлыг ил тод болон нууцаар өгөх арга зам, авах арга хэмжээ, хариуцах албан тушаалтныг хамт олны саналаар томилох талаар төр, хувийн хэвшлийн байгууллагын дотоод журамд ажлыг эхлүүлэх, 3. Ажилд авахад хүйс, насаар ялгаварлах, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тайлагнасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, • Ялгаварлан гадуурхал, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдлыг ил тод болон нууцаар өгөх арга зам, авах арга хэмжээ, хариуцах албан тушаалтныг хамт олны саналаар томилох талаар зохицуулалт хийж, ажилтнууддаа ил тодорхой мэдээлсэн байгууллагын тоо, дэд салбараар, • Ажилд авахад хүйс, насаар ялгаварлах, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлсэн ажлын тоо, 	1. Аж ахуйн нэгж, байгууллагууд жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, ЖСЗ-д тайлагнах удирдамжийг салбарын хэмжээнд түгээн дэлгэрүүлж мөрдүүлэх, 2. Салбарын төр, хувийн хэвшлийн нийт байгууллагын дотоод журамд ялгаварлан гадуурхал, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдлыг ил тод болон нууцаар өгөх арга зам, авах арга хэмжээ, хариуцах албан тушаалтныг хамт олны саналаар томилох талаар тусгах, 3. Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг ажлын байранд, хамт олон удирдлагын зүгээс хамгаалах, дэмжих чиглэлээр зөвлөмж гарган түгээх, 4. Ажилд авахад хүйс, насаар ялгаварлах, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.	<ul style="list-style-type: none"> • Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, тайлагнасан аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь, дэд салбараар, • Ялгаварлан гадуурхал, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдлыг ил тод болон нууцаар өгөх арга зам, авах арга хэмжээ, хариуцах албан тушаалтныг хамт олны саналаар томилж, ажилтнууддаа ил тодорхой мэдээлсэн байгууллагын эзлэх хувь, дэд салбараар, • Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг ажлын байранд, хамгаалах, дэмжих талаар зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо, • Ажилд авахад хүйс, насаар ялгаварлах, ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, 	
	4. Малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, залгамж халааг бэлтгэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх;	1. Залуу малчин эмэгтэй, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа хийж үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх, 2. Малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, малчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээг жендэрийн судалгаа, шинжилгээний үндсэн дээр тодорхойлон салбар, орон нутгийн бодлого төлөвлөлтөд тусгах, 3. Малчин эмэгтэйчүүдийн өрх, багийн түвшин дэх үйлдвэрлэлийг, түүний дотор сүү, цагаан идээний үйлдвэрлэл, арьс	<ul style="list-style-type: none"> • Залуу малчин эмэгтэй, эрэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаарх жендэрийн судалгааны хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Малчин гэр бүлийн хөгжлийг дэмжих, малчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх нийгэм соёл, эдийн засгийн цогц арга хэмжээг тусгасан бодлогын баримт бичгийн тоо, • Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих 	1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийг хамгаалах, эхний хариу үйлдэл үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх боломжийг мэргэжлийн ТББ-уудтай хамтран судалж, зөвлөмж гаргах, 2. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн харилцаа, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр малчин эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн мэдээлэл сурталчилгааны материал бэлтгэн багийн дарга, малын эмч нараар түгээлгэх,	<ul style="list-style-type: none"> • Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн малчин эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийг хамгаалах, эхний хариу үйлдэл үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр хийсэн судалгааны тайлан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүлийн харилцаа, гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр мэдээлэл авсан малчин 	

			<p>шир, ноос ноолуурын түүхий эд бэлтгэлийг бага оврын тоног төхөөрөмжөөр дэмжих чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх,</p> <p>4. Малчин эмэгтэйчүүдэд сүү, цагаан идээ боловсруулах, арьс шир, ноос ноолуурын түүхий эдийг бэлтгэх ур чадвар, мэргэшил олгох сургалтын тогтолцоог орон нутагт бий болгох туршилтын төслийг хэрэгжүүлэх,</p> <p>5. Орон нутгийн санаачлагаар хэрэгжүүлж буй малчдын залгамж халаа бэлтгэхэд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөр, жишээлбэл Дундговь аймгийн “Залуу малчдын эгнээг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд жендэрийн үр нөлөөний үнэлгээ хийх,</p> <p>6. Малчдын хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ хүргэх, эцэг эхтэй нь хамт зайнаас сургах гэх мэт оновчтой арга замыг өнөөгийн боловсролын тогтолцооны хүрээнд тодорхойлон турших.</p>	<p>бага оврын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж, нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж буй байгууллагын тоо, байгууллагын төрлөөр,</p> <ul style="list-style-type: none"> • Малчин эмэгтэйчүүдэд сүү, цагаан идээ боловсруулах, арьс шир, ноос ноолуурын түүхий эдийг бэлтгэх ур чадвар, мэргэшил олгох сургалтын тогтолцоог орон нутагт бий болгох туршилтын төсөлд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, • Дундговь аймгийн “Залуу малчдын эгнээг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн жендэрийн үр нөлөөний үнэлгээний тайлангийн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Малчдын хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ хүргэх, эцэг эхтэй нь хамт зайнаас сургах оновчтой арга замыг тодорхойлох, туршихад чиглэсэн арга хэмжээний тоо. 	<p>3. Малчин эмэгтэйчүүдийн өрх, багийн түвшин дэх үйлдвэрлэлийг, түүний дотор сүү, цагаан идээний үйлдвэрлэл, арьс шир, ноос ноолуурын түүхий эд бэлтгэлийг бага оврын тоног төхөөрөмжөөр дэмжих чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх,</p> <p>4. Малчин эмэгтэйчүүдийн органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих сургалт, маркетингийн сүлжээг үндэсний болон орон нутгийн түвшинд хөгжүүлэх,</p> <p>5. “Залуу малчдын эгнээг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд жендэрийн үр нөлөөний үнэлгээний үр дүнд суурилан сайн туршлагыг сурталчлан түгээн дэлгэрүүлэх,</p> <p>6. Малчдын хүүхдэд боловсролын үйлчилгээ хүргэхдээ эцэг эхийн боловсролыг хамт дээшлүүлэх тогтолцоог хөгжүүлэх,</p> <p>7. Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн үйл ажиллагаанд эмэгтэй эрэгтэйчүүдийг, нийгмийн бүлгүүдийг тэгш оролцуулах чиглэлээр зөвлөмж гарган холбогдох байгууллагуудад түгээх.</p>	<p>эрэгтэйчүүдийн хувь, орон нутгаар,</p> <ul style="list-style-type: none"> • Малчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих бага оврын тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж, нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж буй байгууллагын тоо, байгууллагын төрлөөр, • Малчин эмэгтэйчүүдийн органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих сургалт, маркетингийн сүлжээнд ажиллагчдын тоо, хүйсээр • Залуу малчдын эгнээг өргөжүүлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлсэн орон нутгийн тоо, • Хүүхэдтэйгээ хамт зайны сургалтаар боловсролоо дээшлүүлсэн малчдын тоо, хүйсээр, • Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн гишүүдийн тоо, хүйсээр.
	<p>5. Хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийн технологи, сургалт, санхүү-зээлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлж, эмэгтэйчүүд ажиллах нөхцлийг сайжруулах;</p>	<p>1. Органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах технологийг сайжруулах, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх бүх шатанд эмэгтэй эрэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, тэдний ялгаатай туршлага, хэрэгцээг анхаарч тооцох чиглэлээр холбогдох албан тушаалтнуудад удирдамж боловсруулан хүргүүлэх,</p> <p>2. Хүнсний ногоо, жимс жимсгэнийг орон нутгийн болон гадаад дотоодын зах зээлд борлуулах маркетингийн сүлжээг хөгжүүлэх боломжийг судлан хэлэлцүүлэг хийх,</p> <p>3. Ногоочдод зориулсан ногоон зээл олгох туршилтын төслийг ОУБ, ТББ-уудтай хамтран хэрэгжүүлэх,</p> <p>4. Хүлэмжийн аж ахуй эрхлэх сургалт, хөрөнгө оруулалтын дэмжлэгийн</p>	<ul style="list-style-type: none"> • Органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах технологийг сайжруулах, борлуулалтын сүлжээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэх чиглэлээр удирдамж хүргэсэн албан тушаалтны тоо, орон нутгаар, • Хүнсний ногоо, жимс жимсгэнийг орон нутгийн болон гадаад дотоодын зах зээлд борлуулах маркетингийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр хийсэн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Ногоон зээлд хамрагдсан ногоочдын тоо, хүйсээр, 	<p>1. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ үйлдвэрлэгчдэд зориулсан санхүү, техник, хөдөлмөр хөнгөвчлөх технологи, бордооны дэмжлэг үзүүлэх жендэрийн хувьд ээлтэй тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэл, ТББ-уудын нөөц боломж, туршлагад тулгуурлан бүрдүүлэх.</p> <p>2. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ үйлдвэрлэгчдэд, түүний дотор шинэ таримал нутагшуулагчдад хаврын тариалалтаас борлуулалт хүртэлх бүх шатанд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ өгөх эрх зүй, бодлогын орчныг бүрдүүлж, хүний нөөцийг бэлтгэх,</p> <p>3. Органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах технологийг сайжруулах, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд жендэрийн үнэлгээ хийж зөвлөмж гаргах,</p>	<ul style="list-style-type: none"> • Хүнсний ногоо, жимс жимсгэнэ үйлдвэрлэгчдэд зориулсан санхүү, техник, хөдөлмөр хөнгөвчлөх технологи, бордооны дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж буй төр, хувийн хэвшлийн байгууллага, ТББ-ын тоо, • Хүнсний ногоо, жимс жимсгэнэ үйлдвэрлэгчдэд, түүний дотор шинэ таримал нутагшуулагчдад зөвлөх үйлчилгээ гэрээлэн үзүүлж буй хүмүүсийн тоо, хүйсээр, • Органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хадгалах технологийг сайжруулах, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн 	

		хүртээмжийг нэмэгдүүлж, шаардагдах дэд бүтцийг хөгжүүлэх,	<ul style="list-style-type: none"> • Хүлэмжийн аж ахуй эрхлэх сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо, хүйсээр • Хүлэмжийн аж ахуй эрхлэхэд хөрөнгө оруулалтын дэмжлэг авсан аж ахуйн нэгжийн удирдлагын тоо, хүйсээр, 	4. Эмэгтэй, эрэгтэй ногоочдод ногоон зээл ялгаатай хэрэгцээнд нийцсэн нөхцлөөр хүртээмжтэй олгох байнгын тогтолцоог хувийн хэвшил, ОУБ, ТББ-уудтай хамтран бий болгох,	<p>жендэрийн үнэлгээний тайлан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр,</p> <ul style="list-style-type: none"> • Ногоон зээлд хамрагдсан ногоочдын тоо, хүйсээр,
6. Хөдөө аж ахуйн зохистой дадлыг малчин, тариаланч эмэгтэй эрэгтэйчүүдийн жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн эзэмшүүлж, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх;	<ol style="list-style-type: none"> 1. Химийн бодисын хэрэглээний талаар хүлэмжийн аж ахуй эрхлэгч, хүнсний ногоо тариалагч, төмс, үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэй, эрэгтэйчүүдэд зориулсан гарын авлага, зааварчлагыг жендэрийн мэдрэмжтэй боловсруулан түгээх, 2. Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдийг уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд өрхийн төсөв санхүү, аж ахуйг зохистой хэрэглээ ба тогтвортой хөгжлийн чиг хандлагаар төлөвлөж, хөтлөх чиглэлээр ажил үүргийн хуваарьтай нь уялдуулан чадавхижуулах стратеги боловсруулан хэрэгжүүлэх, 3. Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг эзэмшүүлэх зэрэг малчид, фермерүүд, газар тариалан эрхлэгчдэд шинэ мэдлэг мэдээлэл, ур чадвар олгоход чиглэсэн гарын авлага, мэдээлэл сурталчилгааны жендэрийн мэдрэмжийг сайжруулах чиглэлээр оролцогч талуудад сургалт хийх, 	<ul style="list-style-type: none"> • Химийн бодисын хэрэглээний талаар гарын авлага, зааварчлага авсан хүлэмжийн аж ахуй эрхлэгч, хүнсний ногоо тариалагч, төмс, үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо, хүйсээр, • Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд өрхийн төсөв санхүү, аж ахуйг төлөвлөн хөгжүүлэх талаар малчин эмэгтэй эрэгтэйчүүдийг чадавхижуулахад чиглэсэн үйл ажиллагааны тоо, орон нутгаар, • Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг эзэмшүүлэх гарын авлага, мэдээлэл сурталчилгааны жендэрийн мэдрэмжийг сайжруулах сургалтад оролцогчдын тоо, хүйс, байгууллагаар. 	<ol style="list-style-type: none"> 1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд аж ахуйн төлөвлөлт хийх, байгалийн нөөцийн зохистой ашиглалт хамгаалалт болон орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чадавхи олгох сургалтын хөтөлбөр боловсруулан хэвлэл мэдээлэл, боловсролын тогтолцоогоор дамжуулан хүргэх. 2. Химийн хорт бодисын эмэгтэй, эрэгтэй хүмүүст, хүүхдүүдэд, жирэмсэн эхчүүдэд нөлөөлөх байдлын талаар гадаад улс орнуудад хийгдсэн судалгаа шинжилгээний тойм гарган хэвлэж холбогдох байгууллагуудад түгээх, 3. Хөдөө аж ахуйн зохистой дадлыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалт, мэдээллийг эмэгтэй эрэгтэйчүүдийн өдөр тутмын ажил үүрэгтэй уялдуулан жендэрийн мэдрэмжтэй хүргэх чадавхи олгох сургалт хийх, 4. Малчид, тариаланчдад төрөөс үзүүлж буй тусламж дэмжлэгийг тэдний нийгмийн хариуцлагатай уялдуулах боломжийг судлан, арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх, 	<ul style="list-style-type: none"> • Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд аж ахуйн төлөвлөлт хийх, байгалийн нөөцийн зохистой ашиглалт хамгаалалт болон орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чадавхи олгох сургалтын хөтөлбөрийг хүргэсэн мэдээллийн хэрэгсэл, боловсролын байгууллагын тоо, • Химийн хорт бодисын эмэгтэй, эрэгтэй хүмүүст, хүүхдүүдэд, жирэмсэн эхчүүдэд нөлөөлөх байдлын талаар гадаад улс орнуудад хийгдсэн судалгаа шинжилгээний тойм түгээсэн хувийн тоо, • Хөдөө аж ахуйн зохистой дадлыг жендэрийн мэдрэмжтэй эзэмшүүлэх чадавхи сургалтад хамрагдагчдын тоо, хүйсээр, • Малчид, тариаланчдад төрөөс үзүүлж буй тусламж дэмжлэгийг тэдний нийгмийн хариуцлагатай уялдуулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, 	
7. ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлд ажиллаж буй эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, орон нутагт суурилсан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, бизнес инкубаторын хүртээмжтэй	<ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн түвшинд ЖДҮ-ийн чиглэлээр хийгдэж буй сургалтуудад жендэрийн үнэлгээ хийх, 2. ЖДҮ эрхлэгчдийг жендэрт ээлтэй хөдөлмөр зохион байгуулалт, бизнес төлөвлөлтийн асуудлаар чадавхижуулах, 3. Бизнес инкубатор, МСҮТ-ээс орон нутгийн нөөц боломж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн сургалтын хэрэгцээг тодорхойлон, сургалтын хөтөлбөр модуль боловсруулан шинээр суралцах болон 	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн түвшинд ЖДҮ-ийн чиглэлээр хийгдэж буй сургалтууд хийсэн жендэрийн үнэлгээний тайлан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Жендэрт ээлтэй хөдөлмөр зохион байгуулалт, бизнес төлөвлөлтийн чиглэлээр мэдлэг олгох агуулгатай сургалтад хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн тоо, хүйсээр, орон нутгаар, 	<ol style="list-style-type: none"> 1. Орон нутагт ажиллаж буй өрхийн ЖДҮ-ийн үйлчилгээний салбарын хэрэгцээнд тохирсон мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, бизнес инкубаторын тоо, төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх, 2. Орон нутгийн нөөц боломж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ЖДҮ-ийн сургалтын хэрэгцээг тодорхойлон, сургалтын хөтөлбөр модуль боловсруулан шинээр суралцах болон мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах загвар төслийн үр дүнг үнэлж туршлагыг түгээн дэлгэрүүлэх, 	<ul style="list-style-type: none"> • Орон нутагт ажиллаж буй өрхийн ЖДҮ-ийн үйлчилгээний салбарын хэрэгцээнд тохирсон мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, бизнес инкубаторын тоо, төрлөөр, • Орон нутгийн нөөц боломж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн ЖДҮ-ийн сургалтын хэрэгцээг тодорхойлон, сургалтын хөтөлбөр модуль боловсруулан ашиглаж буй 	

		тогтолцоо бий болгох;	мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах загвар төсөл турших.	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн нөөц боломж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн сургалтын хэрэгцээг тодорхойлон, сургалтын хөтөлбөр модуль боловсруулан туршсан бизнес инкубатор, МСҮТ-ийн тоо, орон нутгаар. 	<p>3. Малчин өрхүүдэд зориулсан аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг тогтоон, хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зохицуулалт хийх,</p> <p>4. Соёлын ялгааг мэдэрч, ялгаатай хэрэглэгчдийн хэрэгцээнд тааруулах чадварыг үйлчилгээний байгууллагууд, аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх хөдөөгийн айл өрхүүдэд олгох гарын авлага боловсруулан түгээх,</p>	<p>МСҮТ, бизнес инкубаторын тоо,</p> <ul style="list-style-type: none"> Малчин өрхүүдэд зориулсан аялал жуулчлалын үйлчилгээний стандарт, Малчин өрхүүд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхэд хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зохицуулалт, Соёлын ялгааг мэдэрч, ялгаатай хэрэглэгчдийн хэрэгцээнд тааруулах гарын авлагыг хүргэсэн байгууллага, малчин өрхийн тоо, орон нутгаар.
	8. Салбарт ажиллагч эмэгтэй эрэгтэйчүүдийн жендэрийн тэгш оролцоог дэмжих орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагчдын чадавхийг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх;	<p>1. Орон нутагт ахуй үйлчилгээг хөгжүүлж, амьдрах орчныг сайжруулахад бодлогоор дэмжлэг үзүүлж, байраар хангах асуудлыг орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх чиглэлээр удирдамж чиглэлээр хангах,</p> <p>2. Орон нутгийн ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэмжиж, орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хэрэгцээнд гэрээлэн нийлүүлэх чиглэлээр удирдамж чиглэлээр хангах,</p> <p>3. Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих, зохистой хэрэглээний дадлыг төлөвшүүлэх үүрэг хариуцлагыг тодорхой тусгах,</p> <p>4. Нийслэлийн гэр хороолол, аймаг, сумын төвд суурин болон улирлын байдалтай амьдарч буй бүх насны эмэгтэйчүүдэд зориулсан ногоон ажлын байрыг⁶ бий болгох боломжийг салбарын хэмжээнд хэлэлцэн тодорхойлж зохицуулалтаар хангах .</p>	<ul style="list-style-type: none"> Орон нутгаас байраар ханган ажиллуулж буй ахуй үйлчилгээний байгууллагуудын тоо, үйл ажиллагааны чиглэлээр, Орон нутгийн ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрийн болон хувийн хэвшлийн хэрэгцээнд нийлүүлэхээр хийсэн гэрээний тоо, үнийн дүн, орон нутгаар Нийслэлийн гэр хороолол, аймаг, сумын төвд суурин болон улирлын байдалтай амьдарч буй бүх насны эмэгтэйчүүдэд зориулсан ногоон ажлын байрыг бий болгох талаар хийсэн хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр. 	<p>1. Орон нутагт ахуй үйлчилгээг хөгжүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлж, байраар хангах асуудлыг орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэх,</p> <p>2. Орон нутгийн ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэмжиж, орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хэрэгцээнд, тухайлбал “Үдийн цай” хөтөлбөрт гэрээлэн нийлүүлэх чиглэлээр гарсан сайн туршлагыг судлан түгээн дэлгэрүүлэх,</p> <p>3. Хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллах эрэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлсэн орон нутгийн туршлагыг судлан түгээн дэлгэрүүлэх,</p> <p>4. Орон нутгийн түвшинд төрийн бус байгууллагуудыг хөдөөгийн хөгжил дэх жендэрийн асуудлаар ажиллахад чадавхижуулах, гэрээлэн ажиллуулах талаар орон нутгийн удирдлагуудыг чиглэл удирдамжаар хангах.</p>	<ul style="list-style-type: none"> Орон нутгаас байраар ханган ажиллуулж буй ахуй үйлчилгээний байгууллагуудын тоо, үйл ажиллагааны чиглэлээр, Орон нутгийн ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний төрийн болон хувийн хэвшлийн хэрэгцээнд нийлүүлэхээр хийсэн гэрээний тоо, үнийн дүн, орон нутгаар Орон нутгийн бүтээгдэхүүнээр “Үдийн цай” хөтөлбөрийг хангаж буй орон нутгийн тоо, Хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллах эрэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлсэн орон нутгийн тоо, бүсээр, Төрийн бус байгууллагуудыг хөдөөгийн хөгжил дэх жендэрийн асуудлаар гэрээлэн ажиллуулсан орон нутаг, байгууллагын тоо. 	
3. Үндэсний ба олон улсын түвшин дэх жендэрийн түншлэл, хамтын	ХХААХҮ-ийн салбарт тулгамдаж буй жендэрийн асуудлыг	1. ХХААХҮ-ийн салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн	1. ХХААХҮ-ийн салбарын бодлоготой уялдуулан, ажлын байрын бодит захиалга, хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүний нөөц бэлдэх чиглэлээр ХХААХҮ, ХНХЯ, БСШУСЯ-ны хамтарсан зөвлөмж гаргаж хэрэгжүүлэх,	<ul style="list-style-type: none"> ХХААХҮ-ийн салбарын бодлоготой уялдуулан, ажлын байрын бодит захиалга, хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүний нөөц бэлдэх чиглэлээр гаргасан 	1. ХХААХҮ-ийн салбарын мэргэжлүүдээр суралцагчдын хүйсийн харьцааг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн түр тусгай арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөнд үнэлгээ хийх,	<ul style="list-style-type: none"> Салбарын мэргэжлүүдээр суралцагчдын хүйсийн харьцаа,

⁶ Жишээ нь нэхмэл, сүлжмэлийн цехүүд

<p>ажиллагаагаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийг дэмжих;</p>	<p>шийдэх салбар дундын зохицуулалт, түншлэл хамтын ажиллагаа үндэсний болон орон нутгийн түвшинд сайжирч, олон улсын түвшинд салбарын жөндөрийн асуудлаар манлайлан ажиллах чадавхи бүрдэнэ.</p>	<p>салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааг дэмжих;</p>	<ol style="list-style-type: none"> Мал аж ахуй, газар тариалангийн салбарын мэргэжлүүдээр суралцагчдын хүйсийн харьцаанд эмэгтэйчүүд давамгайлах хандлагыг анхаарч, эрэгтэйчүүдийн элсэлтийг дэмжсэн түр тусгай арга хэмжээ авах, Хүнс, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр суралцагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор боловсролын байгууллагуудтай хамтын тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, Явуулын эрүүл мэндийн оношлогоо үйлчилгээг малчин эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, шаардагдах судалгаа, мэдээллийг бэлтгэн ЭМЯ-нд хүргэх, Малчдын ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах зөөврийн төхөөрөмжийг байгаль орчин, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбаруудын инновацийн үйл ажиллагааны хүрээнд бүтээж турших. 	<p>зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловсролын байгууллагын тоо,</p> <ul style="list-style-type: none"> Мал аж ахуй, газар тариалангийн салбарын мэргэжлүүдээр суралцагчдын хүйсийн харьцаа, Хүнс, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр тэтгэлгээр суралцагчдын тоо, хүйсээр, Малчин эрэгтэйчүүдийн талаар ЭМЯ-нд гаргаж өгсөн үзүүлэлтийн тоо, Малчдын ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах зөөврийн төхөөрөмжийг бүтээх, туршихад зарцуулсан санхүүжилтийн хэмжээ. 	<ol style="list-style-type: none"> Хүнс, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр суралцагчдын тоог нэмэгдүүлэх тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Малчдын ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах зөөврийн төхөөрөмжийг ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төвүүдээр дамжуулан сурталчлан түгээх Өрхийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээллэгийн талаарх мэдээллийг хот хөдөөгийн эмэгтэйчүүдэд олгох сургалт, нөлөөллийг ЭМЯ-тай хамтран өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан хийх, 	<ul style="list-style-type: none"> Хүнс, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр тэтгэлгээр суралцагчдын тоо, хүйсээр, Малчдын ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах зөөврийн төхөөрөмжийг бүтээх, туршихад зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, Малчдын ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг сайжруулах зөөврийн төхөөрөмж ашиглаж буй малчин өрхийн тоо, орон нутгаар, Өрхийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээллэгийн талаарх мэдээлэл эмэгтэйчүүдэд олгож буй эрүүл мэндийн төвүүдийн тоо, орон нутгаар,
		<p>2. Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолын хэрэгжилтийг үндэсний болон бүс нутгийн түвшинд манлайлах чадавхийг бэхжүүлэх;</p>	<ol style="list-style-type: none"> Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолыг монгол хэлээр хэвлэх, Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх асуудлаар салбар дундын хэлэлцүүлэг зохион байгуулах, Тогтоолын хэрэгжилтийг тайлагнах чиглэлээр салбарын холбогдох ажилтнуудад сургалт хийх, Үндэсний болон орон нутгийн түвшинд хөдөөгийн хөгжил, орон нутгийн хөгжил, нийгмийн асуудлаар ажиллаж буй төрийн бус байгууллагуудыг Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолын хэрэгжилтэд оролцох талаар чадавхижуулах сургалтууд зохион байгуулах Хөдөөгийн хөгжлийг дэмжин эмэгтэйчүүд ажиллах боломжийг сайжруулах чиглэлээр гадаад орнуудтай, түүний дотор Швед, Норвеги, Дани, Финлянд зэрэг ижил төстэй нөхцөл байдал үүссэн орнуудтай 	<ul style="list-style-type: none"> Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолыг монгол хэлээр хэвлэн түгээсэн хувийн тоо, Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолын хэрэгжилтийн асуудлаар хийсэн хэлэлцүүлэгт оролцогч байгууллагуудын тоо, оролцогчдын тоо, хүйсээр, Тогтоолын хэрэгжилтийг тайлагнах чиглэлээр сургалтад хамрагдагчдын тоо, хүйсээр, Тогтоолтой холбоотой олон улсын арга хэмжээнд оролцсон салбарын ажилтны тоо, хүйсээр, Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах НҮБ-ын тогтоолын асуудлаар сургалтад хамрагдсан ТББ- 	<ol style="list-style-type: none"> Үндэсний болон бүс нутгийн түвшинд тогтоолыг хэрэгжүүлэх туршлага солилцох, хамтын ажиллагааг эхлүүлэх уулзалт, бага хурал зохион байгуулах, Тогтоолын хэрэгжилтийг дэмжих чиглэлээр бүсийн хэмжээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх платформ санаачлан байгуулах, Мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдэд бүс нутгийн, орон нутгийн хэрэгцээнд тохирсон нэмүү өртгийн сүлжээний талаар мэдлэг өгөх тогтолцоог бий болгох , Хөдөөгийн өрхүүдэд чиглэсэн нэмүү өртгийн сүлжээний бүс нутгийн түвшний загвар төслийг санаачлан хэрэгжүүлж, үр нөлөөг үнэлэх, Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл дэх хөдөөгийн ногоон хөгжлийн загвар төслийг бэлчээрийн мал аж ахуйд түшиглэн хэрэгжүүлж, үр дүнг үндэсний болон олон улсын түвшинд сурталчлан түгээх, Хөдөөгийн хөгжилд жөндөрийн тэгш оролцоог хангах чиглэлээр Швед, 	<ul style="list-style-type: none"> Үндэсний болон бүс нутгийн түвшинд тогтоолын хэрэгжилтийн асуудлаар зохион байгуулсан бага хурал, уулзалтын тоо, оролцогчдын тоо, хүйсээр, Тогтоолын хэрэгжилтийг дэмжих бүсийн платформд оролцогч улс орнуудын тоо, Бүс нутгийн, орон нутгийн хэрэгцээнд тохирсон нэмүү өртгийн сүлжээний талаар мэдлэг өгөх сургалтад хамрагдсан мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн тоо, хүйсээр, Хөдөөгийн өрхүүдэд чиглэсэн нэмүү өртгийн сүлжээний бүс нутгийн түвшний загвар төсөлд хамрагдагчдын тоо, хүйсээр, төслийн туршлага солилцох уулзалтад оролцсон салбарын ажилтнуудын тоо, хүйсээр,

		<p>туршлага солилцож дэвшилтэт технологийг нэвтрүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлэх,</p> <p>6. Өрх толгойлсон малчин тариаланч эмэгтэйчүүдийг чадавхижуулах төслийг үндэсний түвшинд хэрэгжүүлэх,</p>	<p>уудын тоо, үйл ажиллагааны чиглэлээр,</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн хөгжлийг дэмжин эмэгтэйчүүд ажиллах боломжийг сайжруулах чиглэлээр хамтран ажилласан орнуудын тоо, хөрөнгө оруулалтын хэмжээ, • Өрх толгойлсон малчин тариаланч эмэгтэйчүүдийг чадавхижуулах төслийн үр шимийг хүртэгчдийн тоо, байршлаар. 	<p>Норвеги, Дани, Финлянд зэрэг ижил төстэй нөхцөл байдалтай орнуудын туршлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх,</p> <p>7. Хөдөө орон нутагт дижитал дэд бүтцийг бий болгож ложистикийн сүлжээг малчдад хүргэх, олон улсын түвшин дэх техник технологи, ур чадвар шилжүүлэх үйл явцыг хөдөө аж ахуйн салбарт чиглүүлэхэд бүс нутгийн улс орнуудтай хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх,</p> <p>8. Сүргийн бүтцийг зохистой болгож, бэлчээр хамгаалах, зохистой ашиглахад чиглэсэн хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг өрнүүлж, дэмжих чиглэлээр ажилладаг ТББ-уудтай хамтран ажиллах.</p>	<ul style="list-style-type: none"> • Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл дэх хөдөөгийн ногоон хөгжлийн загвар төслийн үр дүнг үндэсний болон олон улсын түвшинд сурталчилсан арга хэмжээний тоо, • Хөдөөгийн хөгжилд жендэрийн тэгш оролцоог хангах чиглэлээр Швед, Норвеги, Дани, Финлянд зэрэг ижил төстэй нөхцөл байдалтай орнуудын туршлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, • Хөдөө орон нутагт дижитал дэд бүтцийг бий болгож ложистикийн сүлжээг малчдад хүргэх, олон улсын түвшин дэх техник технологи, ур чадвар шилжүүлэх үйл явцыг хөдөө аж ахуйн салбарт чиглүүлэхэд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, • Сүргийн бүтцийг зохистой болгож, бэлчээр хамгаалах, зохистой ашиглахад чиглэсэн хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг өрнүүлж, дэмжих чиглэлээр хамтран ажилласан ТББ-уудын тоо.
<p>3. Бүх түвшний хэрэглэгчдийн жендэрийн ялгаатай үүрэг ба хэрэгцээнд тулгуурлан үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, зохистой хэрэглээг төлөвшүүлэх үндэсний чадавхийг хөгжүүлэх;</p>	<p>1. Хот хөдөөгийн айл өрхүүдийн хүнсний өдөр тутмын хэрэглээ, худалдан авалт, санхүүгийн төлөвлөлтөд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаар судалгаа хийх,</p> <p>2. Хот хөдөөгийн айл өрхүүдийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээллэгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хэвлэл мэдээллийн стратегийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулан хэрэгжүүлэх,</p> <p>3. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг, амьдралын хэрэгцээтэй нь уялдуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн</p>	<ul style="list-style-type: none"> • Хот хөдөөгийн айл өрхүүдийн хүнсний өдөр тутмын хэрэглээ, худалдан авалт, санхүүгийн төлөвлөлтөд хийсэн жендэрийн судалгааны тайлан, хэлэлцүүлэгт оролцогчдын тоо, хүйсээр, • Хот хөдөөгийн айл өрхүүдийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээллэгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний тоо, • Монгол орны цаг агаар, уур амьсгалын онцлогт тохирсон, бүх насны эмэгтэй эрэгтэй 	<p>1. Монгол орны цаг агаар, уур амьсгалын онцлогт тохирсон, бүх насны эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн хувцас хэрэглэлийн жендэрийн мэдрэмжтэй стандартыг төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад гол шалгуур болгон ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх,</p> <p>2. Хот хөдөөгийн айл өрхүүдийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээллэгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийн стратегийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх,</p> <p>3. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн гүйцэтгэх үүрэг, амьдралын</p>	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн хувцас хэрэглэлийн жендэрийн мэдрэмжтэй стандартыг төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад гол шалгуур болгохыг заасан эрх зүйн зохицуулалт, • Хот хөдөөгийн айл өрхүүдийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээллэгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүний тоо, 	

			<p>мэдээллийг телевиз, интернэтээр жендэрийн мэдрэмжтэй боловсруулж бие даасан нэвтрүүлэг, шторк гэх мэт төрөл бүрийн хэлбэрээр түгээх,</p> <p>4. Монгол орны цаг агаар, уур амьсгалын онцлогт тохирсон, бүх насны эмэгтэй эрэгтэй хүмүүсийн, охид хөвгүүдийн хувцас хэрэглэлийн жендэрийн мэдрэмжтэй стандарт тогтоох,</p>	<p>хүмүүсийн, охид хөвгүүдийн хувцас хэрэглэлийн жендэрийн мэдрэмжтэй стандартыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо,</p>	<p>хэрэгцээтэй нь уялдуулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээллийг телевиз, интернэтээр жендэрийн мэдрэмжтэй боловсруулж бие даасан нэвтрүүлэг, шторк гэх мэт төрөл бүрийн хэлбэрээр түгээх,</p> <p>4. Охид хөвгүүдэд үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй, зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээллийг боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх,</p> <p>5. Эмэгтэй эрэгтэй хүмүүст, охид хөвгүүдэд үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй, зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж, гэрээлэн гүйцэтгүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> Охид хөвгүүдэд үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй, зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл бүхий боловсролын хөтөлбөрийн тоо, Эмэгтэй эрэгтэй хүмүүст, охид хөвгүүдэд үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, байгаль орчинд ээлтэй, зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр гэрээлэн ажилласан ТББ-ын тоо.
	<p>4. ХХААХҮ-ийн салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад донор орнууд, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа, үр өгөөжийг сайжруулах;</p>	<p>1. Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжих чиглэлээр доноруудын уулзалт хийх,</p> <p>2. Салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх,</p> <p>3. Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны нэгдсэн удирдамж гарган түгээх,</p> <p>4. Газар тариалангийн зохистой үйлдвэрлэлийн чиглэлээрх сургалт, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх төслүүдийн эмэгтэйчүүдийг хүнсний ногоо дахин боловсруулах, бичил бизнесийг хөгжүүлэх, бүлэг хоршоогоор ажиллахад дэмжлэг үзүүлэх чиглэлийг жендэрийн бодлогын хэрэгжилттэй уялдуулах.</p>	<ul style="list-style-type: none"> Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжих уулзалтад оролцсон донор байгууллагуудын тоо, Салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийн нэгдсэн сан, Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд доноруудаас дэмжлэг үзүүлсэн санхүүжилтийн хэмжээ. 	<p>1. Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжих чиглэлээр доноруудын уулзалтыг тогтмолжуулах,</p> <p>2. Салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэн, үйл ажиллагаанд ашиглах,</p> <p>3. Газар тариалан, мал аж ахуй, хүнсний болон хөнгөн үйлдвэрийн чиглэлээр шинээр боловсруулагдаж хэрэгжих төслүүдийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг жендэрийн бодлоготой уялдуулах.</p>	<ul style="list-style-type: none"> Салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийг дэмжих уулзалтад оролцсон донор байгууллагуудын тоо, Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд доноруудаас дэмжлэг үзүүлсэн санхүүжилтийн хэмжээ, Салбарын жендэрийн бодлогын хүрээнд донорын дэмжлэгээр хэрэгжсэн төслийн тоо. 	